



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 0/468

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хорооны “Өнө-Ачит” өрхийн эрүүл мэндийн төвийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 6,990,000.0 /зургаан сая есөн зуун ерэн мянган/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хорооны “Өнө-Ачит” өрхийн эрүүл мэндийн төв /Б.Мөнхцэцэг/-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн дүүргийн 13 дугаар хорооны “Өнө-Ачит” өрхийн эрүүл мэндийн төв /Б.Мөнхцэцэг/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

~~ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ~~ Ш.ҮНЭНБАТ

1119282485 Ж.2570588



Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 25 өдрийн дугаар тушаалын хавсралт

Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хорооны Өнө-Ачит ӨЭМТ

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтад авсан огноо	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх үнэ		Эх үүсвэр	
								Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
1	Хаш чулуун ор	SER-AGEM V-3	12 үйлдэлт эй	2019	Сайн	ш	1	6,990,000	6,990,000	УИХ-ын гишүүн Ц.Гарамжав	Хандив
<b>Тоног төхөөрөмжийн дүн</b>								6,990,000	6,990,000		
<b>Нийт бүртгэх дүн</b>								6,990,000	6,990,000		